



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/199

Алтай хот


**Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан
оготной тэмцэх арга хэмжээг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 10.1.6 дахь заапт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн дүгнэлтийн дагуу бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх ажлыг 7 сумын 15.3 мянган га талбайд зохион байгуулан ажил эхлэх өдрөөс 14 хоногийн хугацаанд бэлчээрийн хорио цээр тогтоосугай.
2. Улсын төсвийн хөрөнгөөр үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх сумдын нэр талбайн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тэмцэх сумдын нэр талбайн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Үлийн цагаан оготной тэмцэх ажлын хүрээнд бэлчээр чөлөөлөх ажлыг шуурхай зохион байгуулж, иргэд, малчдын оролцоог хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал, ажиллах хүчний зардалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Үлийн цагаан оготной тэмцэх ажилд ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн албан хаагчдыг томилж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хяналт тавьж, үр дүнг аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлд танилцуулан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ





Аймгийн Засаг даргын 2023 оны 4 дугаар сарын 14-ны өдрийн 199... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ
МИКРОБИОЛОГИЙН АРГААР ТЭМЦЭХ СУМЫН НЭР,
ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

№	Сумдын нэр	Нийт газар нутгийн хэмжээ /га/	Бэлчээрийн хэмжээ /га/	Хөнөөлт мэрэгчид тархсан талбайн хэмжээ /га/	Тэмцэх шаардлагатай талбайн хэмжээ /га/	2023 онд тэмцэх талбайн хэмжээ мян /га/	Шаардлагатай бактержуулсан будаа мян /тн/
1	Жаргалан	368262	320729	150	30	2	3
2	Тайшир	391312	380652.4	90	30	2	3
3	Халиун	521354	277860.5	50	19	1	1.5
4	Бигэр	382632	351098.1	70	36	3	4.5
5	Есөнбулаг	216133	208624.1	50	15	2	3
6	Төгрөг	534328	291414.6	67	17	1.4	1.95
7	Шарга	556585	488737.5	70	26	2	3
	Дүн			547	173	13.4	19.95